

DPUB

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Мэдээллийн эмхтгэл №1



2017 он 10-р сар



"DET Форум Монгол" ТББ байгуулах тухай



Удирдах
зөвлөлийн 5
гишүүн

8-р сарын 30-ны өдөр Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) –ын сургагч багш нарын хурал төслийн оффист зохион байгуулагдлаа. Тус хурлаар ТББ байгуулах талаар хэлэлцсэн бөгөөд цаашид бүтцийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд байгуулж ажиллахаар боллоо. Юуны өмнө сургагч багш нар хуулийн этгээд шинээр бүртгүүлэх зайлшгүй шаардлагатай эсэх талаар хэлэлцсэн ба хуралд оролцогчдын саналаар ТББ байгуулахаар болсон. Улмаар удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүдийг хэрхэн сонгох талаар ярилцлаа. Хурал нийтдээ 3 цаг гаруй үргэлжилсэн бөгөөд удирдах зөвлөлийн 5 гишүүн, хяналтын зөвлөлийн 3 гишүүн, ТББ-ын тэргүүн, дэд тэргүүн нарыг тус тус сонгосон. Тэргүүнээр Энхнямыг сонгож, цаашид “DET Форум Монгол” ТББ-ыг үүсгэн байгуулахтай холбоотой байгууллагын дүрэм боловсруулах гэх мэт ажлуудыг гишүүдийн оролцоотойгоор хийхээр боллоо.




Баянзүрх дүүргийн 27-р хорооны хүртээмжтэй орчинтой танилцлаа

8-р сарын 31-ний өдөр төслийн мэргэжилтнүүд Баянзүрх дүүргийн 27-р хорооны байртай танилцлаа. Тус хорооны хамт олон 4-р сард Хөгжлийн



бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-д хамрагдсан бөгөөд сургалтаар “Үйл ажиллагааны жагсаалт” боловсруулж, холбогдох асуудлуудыг шийдвэрлэжээ. “Төсөв байхгүй учраас бариул суурилуулах, налуу зам засах ажлуудаа өөрсдөө хийсэн.” гэж тус хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хариуцсан ажилтан өгүүлж байлаа. Ялангуяа өрхийн эмнэлгийн хамт олон тэргэнцэртэй иргэдийг зорчиход тохиромжтой болгох зорилгоор хаалгануудын босгыг авч, утгах үйлчилгээний хэсгийн өндөр тавцанг нам ширээгээр солих гэх мэт зөвхөн ХБИ төдийгүй бүх хүмүүст ээлтэй орчинг бүрдүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргаж ажилласан байсан юм. Хороон дарга Батдэлгэр (баруун гар талаас 2 дахь) “Хүмүүс амьдрахад тохиромжтой орчинг бүрдүүлэх нь миний мөрөөдөл” гэж ярьж байсан бөгөөд хорооны нутгийн өөрөө удирдах байгууллагат ХБИ-ийн төлөөлөл ч гэсэн ажиллаж байна. Мөн цаашид ч гэсэн хүн ам ихтэй тус хорооны хүртээмжтэй орчныг улам сайжруулахын төлөө хичээн ажиллах болно гэж өгүүлж байлаа.



Хананд бариул шинээр суурилуулж, хаалганы босгыг авснаар ХБИ-дэд илүү хүртээмжтэй болжээ.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв дээр ажлын уулзалт хийлээ

9-р сарын 1-ний өдөр Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн холбогдох албан хаагчидтай уулзалдан цаашид төслийн зүгээс зохион байгуулах цуврал хичээл болон DET сургалт (Хөгжлийн



бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт) зэргийн талаар санал солилцлоо. Тус төвийн зүгээс 12-р сарын 3-ны ХБИ-ийн эрхийг хамгаалах өдөрт зориулан нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба илүү олон хүмүүсийг хамруулахын тулд арга хэмжээгээ хэрхэн зохион байгуулах талаар голчлон ярилцсан юм. Улмаар хүмүүст мэдээлэл хүргэхийн тулд телевиз, вебсайт, фэйсбүүк зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахаар болсон. Үүнээс гадна цаашид зохион байгуулагдах сургалтуудын талаар ярилцсан бөгөөд Сэргээн засах төвийн даргын зүгээс олон нийтийн байгууллагуудад зориулан нөлөөллийн ажил зохион байгуулж, байгууллагуудыг илүү хүртээмжтэй болгох тал дээр хамтран ажиллаж гэсэн санаачилгыг гаргалаа. Мөн төвийн дарга, албан хаагчид “Шинэ хичээлийн жил эхлэсэн 9-р сарын 1-ний өдөр ач холбогдолтой уулзалт зохион байгуулсандаа баяртай байна” гэж өгүүлж байсан юм. JICA DPUB төслийн фэйсбүүк хуудсанд ч гэсэн цаашид зохион байгуулагдах арга хэмжээнүүдийн тухай нийтэлж та бүхэнд мэдээлэл хүргэх болно.

Монголын Дауны холбооны тэргүүнтэй уулзлаа

Монголын дауны холбооны тэргүүн, Байгаль орчин, ногоон хөгжил / Гадаад хэргийн сайд асан Санжаасүрэнгийн Оюунтай уулзаж төслийнхөө үйл ажиллагааг танилцууллаа. Мөн хатагтай Оюун Монгол улсын хөгжлийн бэрхшээл, улс төр, байгаль орчин зэрэг өргөн салбарын хүрээнд бидэнд зөвлөгөө өглөө. Тухайлбал хөгжлийн бэрхшээлийн салбарын хувьд мэдээлэл цуглуулах, цэгцлэх, түгээх асуудал зайлшгүй шаардлагатай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдээ хэрхэн өсгөж, хүмүүжүүлэх талаар тэр бүр бүрэн ойлголттой байдаггүй. Мөн мэдээлэл түгээх, нөлөөллийн ажил явуулахад хамгийн тохиромжтой хэрэгсэл нь телевизийн суваг гэж өгүүлж байсан юм. Төсөл хэрэгжиж эхлээд хэдийн 1 жилийн нүүрийг үзээд байна. Төслийн зүгээс ч гэсэн цаашид нөлөөллийн ажлуудыг явуулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ утгаараа тус уулзалт ач холбогдолтой болж чадлаа.



Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)



Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст DET сургалтыг зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтын эхний хэсгийг Уянгасайхан (тархины саажилт), сүүлийн хэсгийг Чулуун-Эрдэнэ (хөдөлгөөний бэрхшээл) нар чиглүүлэн явуулсан. Уянгасайханы хувьд анх удаа үндсэн сургагч багшаар оролцсон бөгөөд сургалтын дараа “Маш их сандарсан учраас зарим хэсгийг сайн тайлбарлаж чадаагүй. Дараагийн удаа бэлтгэлээ сайн хийх болно.” гэж байлаа. Сүүлийн хэсгийг чиглүүлэн явуулсан Чулуун-Эрдэнийн хувьд өмнө нь хэд хэдэн удаа үндсэн сургагч багш хийж байсан. Тэрээр сургалтын агуулгыг ойлгомжтойгоор тайлбарлангаа оролцогчидтой ярилцан, багаар ажиллах дасгал ажлуудад туслалцаа үзүүлж байсан юм. Хөгжлийн бэрхшээлийн талаар мэдэж

байгаа юм шиг боловч зөв ойлголт аваагүй байх нь олон байдаг. Энэ удаагийн DET сургалтанд хамрагдсан оролцогчид хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголттой болсон гэдэгт итгэлтэй байна. Мөн оролцогчид иймэрхүү чиглэлийн сургалтуудыг олон нийтэд үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад зохион байгуулах хэрэгтэй гэж сэтгэгдлээ илэрхийлж байлаа.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд япон хэл заахаар боллоо

Монгол - Япон төвийн япон хэлний багш Сайто, Ватанабэ болон Жайкагийн сайн дурын гишүүнээр ирсэн япон хэлний багш Сава нар Хараагүйчүүдийн үндэсний холбооны үйл ажиллагаатай танилцлаа. Монголоос Япон улсад дадлагажагчаар болон суралцахаар явдаг ХБИ цөөнгүй байдаг бөгөөд Хараагүйчүүдийн үндэсний холбооноос ч гэсэн одоогийн байдлаар 3 хүн Япон улсад суралцаж байна. Гэвч тус холбоонд мэргэжлийн багш байхгүй учраас япон хэл сурахад нэлээдгүй бэрхшээл тулгардаг байна.

Сайто багш хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд япон хэл заах гэсэн маш сайхан санаачилгыг гаргаж, энэ удаа төслийн зүгээс Хараагүйчүүдийн үндэсний холбоог танилцууллаа. Тус холбооны дэргэдэх МСҮТ-ийн Ганзориг захирал япон хэлний өндөр мэдлэгтэй бөгөөд мэргэжлийн багш нараар япон хэл заалгах нь үр дүнтэй учраас хамтарч ажиллахдаа таатай байна гэж байлаа.

Хичээлийг 10-р сараас эхлүүлэхээр болсон ба тэр болтол харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан сурах бичиг зэрэг бэлтгэл ажлуудыг хийхээр боллоо.

Төслийн зүгээс ч гэсэн тус санаачлагыг гаргасан багш нарт гүн талархал дэвшүүлж байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй олон хүмүүс япон улсад суралцсанаар тэдний өмнө шинэ ертөнцийн үүд хаалга нээгдэнэ гэдэгт итгэлтэй байна.



Хүний эрхийн үндэсний комиссын холбогдох албан хаагчидтай уулзалдлаа



Хүний эрхийн үндэсний комиссын холбогдох албан хаагчидтай уулзалдан цаашдын хамтын үйл солилцлоо. Тухайлбал, төслийн зүгээс зохион байгуулж буй “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт” (DET)-д “Хүний эрхийн үндэсний комиссын хамт олон ч гэсэн хамрагдах хүсэлтэй” байгаагаа илэрхийлж байсан бөгөөд тус сургалтыг 9-р сарын сүүлээр зохион байгуулахаар боллоо. Хүний эрхийн үндэсний комиссын зүгээс хөгжлийн бэрхшээлийн нөлөөллийн ажлын хүрээнд холбогдох ном, гарын авлагыг манга хэлбэрээр хэвлэх, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг зургаар тайлбарлах гэх мэт илүү олон хүмүүст мэдээлэл, ойлголт өгөх зорилгоор холбогдох ажлуудыг санаачлан, үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн тус комиссын хажууд ойролцоогоор 30 гишүүнтэй сэтгүүлчдийн клуб ажилладаг бөгөөд цаашид тус клубынхэнтэй хамтран хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээ мэдээллийг хүргэх зорилгоор ажиллах болно.



Сайн байцгаана уу, Миний бие “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)”-ийн ахлах зөвлөхөөр ажиллаж байна. Тус төслийн үйл ажиллагаа 2016 оны 5-р сараас эхэлсэн бөгөөд анхны мэдээллийн эмхтгэлээрээ та бүхэнд мэндчилгээ дэвшүүлж байгаадаа баяртай байна. Энэхүү мэдээллийн эмхтгэлийг цаашид сард 2 удаа гаргахаар төлөвлөөд байна.



Манай төслийн товчилсон нэр нь DPUB. Энэ нь Disability Project in Ulaanbaatar гэсэн нэрийн товчлол юм. Сонирхолтой нь манай төслийн нэр өөр 1 утгыг давхар агуулж байдаг. Өөрөөр хэлбэл Disability-Pub. Энэ нь ХБИ идэвхтэй хамтран оролцдог төсөл болж хэрэгжээсэй гэсэн бэлгэдлийг илэрхийлж байна. Тийм учраас цаашдаа ч гэсэн та бүхнийг бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна. Дараагийн дугааруудад “ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих нь” нийгэмд ямар ач холбогдолтой вэ гэх мэт сэдвүүдээр нийтлэл бэлтгэн хүргэх болно.

DPUB Ахлах зөвлөх Чибя Хисао

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>